**“ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР” ХХК-ИЙН СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ “ТӨМӨРТЭЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН ИЛ УУРХАЙН” 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-013319/
/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2051303/

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:
“ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: ____________________ / Б.ЧАГНААДОРЖ /

“ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ИНЖЕНЕР ____________________/П.АЛТАНГЭРЭЛ/

2024 ОН

# Гарчиг


1. Тухайн оны уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга ... 4

*Хүснэгт 1 Төмөртэй уурхайн уулын ажлын гүйцэтгэл 2024.10.28-ны өдрийн байдлаар* ... 5

Хүснэгт 2 Баяжуулах үйлдвэрийн гүйцэтгэл ... 5

2.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ... 6

2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт ... 6

Хүснэгт 3. Зам усалгаа хийсэн байдал ... 7

2.2 Гадаргын ба газрын доорхи усны нөөцөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт ... 11

Хүснэгт 4. Усны төлбөр төлсөн байдал ... 15

2.3. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт ... 16

2.4. Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт ... 20

Хүснэгт 5. Газрын төлбөр ... 20

2.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт ... 21

2.6. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт ... 21

3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт ... 22

4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт: ... 23

5.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ... 24

6.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ... 24

7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт ... 25

7.1 Ажилтнуудын дунд хийгдсэн Эрүүл мэндийн чиглэлийн ажлууд ... 27

Хүснэгт 6. Витамин олголтын мэдээ ... 27

Хүснэгт 7. Артишок олголтын мэдээ ... 27

Хүснэгт 8. Вакцинжуулалтын мэдээ ... 27

8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ... 29

Хүснэгт 9 . Хог хаягдлын мэдээ. 2024.01.01-2024.11.01 ... 32

9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт ... 33

10. Аймаг, сумын Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ ... 35

10.1. Хүдэр сумын ногоон байгууламжийг хамгаалах хамгаалалтын хашаа шийдвэрлэх ... 35

10.2 Хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн хүрээнд Хүдэр сумын төвлөрсөн хогийн цэгийн ахуйн хогыг түрж булшлах ажил ... 35

10.3 Хүдэр сумын хүсэлтийн дагуу хог хаягдал ялгах ажлыг дэмжиж ажилласан ... 36

**10.4** Гамшгийн үед хамтран ажиллах ... 36

10.5 Бусад ажлын хүрээнд ........................................................................................................ 36

11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт ........................................................................................ 37

12.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт ............................................ 38

13. Дүгнэлт........................................................................................................................ 39

Хүснэгт 10 Нийт зарцуулсан зардал ........................................................................ 39

14. Хавсралт: ................................................................................................................... 40



## 1. Тухайн оны уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн харьяа Төмөртэй төмрийн хүдрийн ил уурхай нь Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Баянцагааны 2-р багийн нутагт оршдог. Тусгай зөвшөөрлийн дугаар MV-013319, лицензийн талбайн хэмжээ 1200га юм. Төмөртэй төмрийн хүдрийн ил орд нь төмөр болон авто замаар Улаанбаатар хоттой Дархан хотыг дайрсан замуудаар холбогдоно. Ордын хүдрийн биетийг зүүн хэсэг, баруун хэсэг гэсэн хэсгүүдэд хуваасан ба хүдрийн биетүүд нь нэг хүдрийн бүсэд хамаарагдах ба өөр хоорондоо 2.0-2.5км зайтай оршино. Төмөртэй уурхайг 2010 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр нээж ил уурхайн олборлолтын ажлыг эхлүүлсэн.

Тус уурхай нь ил уурхай, хуурай соронзон баяжуулах үйлдвэр, засварын төв, ажилчдын тосгон, дэд станц зэрэг нэгж хэсгүүдээс бүрдэх бөгөөд жилд 2 сая.тн төмрийн хүдэр олборлож, 2 сая.тн хүдэр боловсруулах хүчин чадалтай юм. Уурхайд 390 орчим ажилчид 14/14 ээлжийн хуваариар ажиллаж байна.

2024 оны 10 дугээр сарын 28-ны өдрийн байдлаар 719510,2$м^3$ хөрс хуулалт хийн, 687253,6тн хүдэр олборлон, 773104,3 тн хүдэр боловсруулж, 454131,5 тн баяжмал үйлдвэрлэж, уулын ажлын гүйцэтгэл 56 хувьтай байна.

*Хүснэгт 1 Төмөртэй уурхайн уулын ажлын гүйцэтгэл 2024.10.28-ны өдрийн байдлаар*

| | | | |
|---|---|---|---|
| Хөрс хуулалт | Төлөвлөгөө | $м^3$ | 1,569,457 |
| | Төлөвлөгөөний.тод | | - |
| | Статистик | | 719,510,2 |
| | Гүйцэтгэл | | 719,510,2 |
| | Биелэлт | % | 51 |
| Хүдэр олборлолт | Төлөвлөгөө | тн | 1,100,000 |
| | Төлөвлөгөөний.тод | | - |
| | Статистик | | 687,253,6 |
| | Гүйцэтгэл | | 687253,6 |
| | Биелэлт | % | 62 |
| Уулын цул | Төлөвлөгөө | | 1,683,000 |
| | Гүйцэтгэл | $м^3$ | 948,595 |
| | Биелэлт | % | 56 |

Хүснэгт 2 Баяжуулах үйлдвэрийн гүйцэтгэл

| | | | |
|---|---|---|---|
| Хүдэр баяжуулалт | Төлөвлөгөө | тн | 1,100,000 |
| | Гүйцэтгэл | тн | 773104,3 |
| | Биелэлт | % | 70 |
| Баяжмал үйлдвэрлэл | Төлөвлөгөө | тн | 605,000 |
| | Гүйцэтгэл | тн | 454,131,5 |
| | Биелэлт | % | 75 |

## 2.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

### 2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

| Д/д | Сөрөг нөлөөллийг бууруулахаар төлөвлөсөн ажил | Сөрөг нөлөөллийг бууруулахаар төлөвлөсөн ажлын биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Уурхайн дотоод тээврийн зам, талбайг усны машин ашиглаж усалж, чийглэх | Хуурайшилт ихтэй саруудад зам талбайд тогтмол усалгаа хийгдсэн | Дотоод зардал | Зам талбайд усалгаа хийсэн байдлыг Хүснэгт-3 с, усалгаа хийж байх үеийн зургийг Зураг-1 с харна уу |
| 2 | Тээврийн хэрэгслийн сул ажиллагааг хязгаарлах, хяналт тавих | Уурхайн ХАБ-ын инженерүүд өдөр тутмын тойрох үзлэгээр явахдаа хяналт тавин ажиллаж байна. | Дотоод зардал | - |
| 3 | Тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах тэмдэг тэмдэглэгээг сайжруулах, шинэ зам үүсгэхгүй байхад анхаарах | - ХАБ-ын инженерүүд хурд хэтрэлтэд тогтмол хяналт тавин ажилладаг ба хурдны хязгаарыг “Авто самосвалын жолоочийн дагаж мөрдөх аюулгүй ажиллагааны заавар”-т тусгаж өгсөн байдаг. Сар бүр хурдны тайланг уурхайн ХАБ-ын инженерүүд гаргаж өгдөг.<br>- Уурхайн бүх замын тэмдэг тэмдэглэгээнүүдийг шинэчилж 90см*90см хэмжээтэй 110 тэмдэг байршуулав. | Дотоод зардал | Уурхайн дотор зорчих тээврийн замын батлагдсан маршрут, хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээний байршлын мэдээллийг Зураг-2,3 с, авто самосвалын жолоочийн батлагдсан заавар, хурдны тайланг Зураг- 2,3 |
| 4 | Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулж, ариутгал хийх | Ахуйн хог хаягдлыг Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын НААҮГ-тай гэрээ байгуулан тогтмол ачуулсан. Хог хаягдал түр хадгалах саванд ачилт бүрийн дараа дотоодын нөөц боломжоор жавелины уусмал ашиглан ариутгал хийдэг. | Дотоод зардал | Тайлангийн 8-р хэсэгт дэлгэрэнгүй тусгасан. |
| 5 | Агаарын бохирдлын талаарх хяналт мониторинг хийхэд шаардлагатай бохирдлыг хэмжих дотоод хяналтын багаж хэрэгсэлтэй болох | Агаарын бохирдлын хяналт мониторинг хийх зориулалтай Тоос, тоосонцор хэмжигч CHD-11 гар багаж худалдан авч дотоод хяналтын хэмжилт хийж ажиллаж байна. | 300,000 | Зураг-4 |
| **НИЙТ** | | | **300,000** | |

Хүснэгт 3. Зам усалгаа хийсэн байдал

| Сар | Нийт усалсан рейс | Усалгаа хийсэн хоног | Нийт усалсан усны хэмжээ, тн |
|---|---|---|---|
| 4 сар | *40* | *4* | *1000* |
| 5 сар | *194* | *21* | *4850* |
| 6 сар | *140* | *18* | *3500* |
| 7 сар | *168* | *22* | *4025* |
| 8 сар | *155* | *25* | *3875* |
| 9 сар | *83* | *15* | *2075* |
| 10 сар | *142* | *14* | *3550* |
| Нийт | ***922*** | ***119*** | ***22875*** |

*Зураг 1. Зам усалгаа*









Мөн агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор уурхайн авто тээврүүдэд хурд хэмжигч суурилуулсан ба хурдны хязгаарыг “Авто самосвалын жолоочийн дагаж мөрдөх аюулгүй ажиллагааны заавар”-т 40 км/ц-аар тогтоосон байдаг ба уурхайн ХАБ-н инженерүүд өдөр тутам хурданд хяналт тавин ажилладаг. Сар бүр хурдны мэдээллийг гарган илэрсэн зөрчлийн дагуу ажилтнуудын KPI /урамшууллын оноо/–г хасаж хариуцлага тооцдог.

*Зураг 2. Авто самосвалын жолоочийн дагаж мөрдөх аюулгүй ажиллагааны заавар*



Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК | А3
Автосамосвал ашиглах ажлын заавар
ДТҮ- А3/23-05-02-037 Хуудас 12 | 20

3.4.4.8 Налуу замд гулгаа үүссэн бол тохирох араанд түгжиж явна

3.4.4.9 Ачаатай өгсөх үедээ автосамосавлын хүч алдуулахгүйн тулд тухайн замын нөхцөлийг үнэлэн тохирох араанд түгжих.

3.4.4.10 Тээвэрлэлтийн замд автосамосвал хоорондын зай багадаа 50 метр байх ба үзэгдэх орчин хязгаарлагдмал үед үүнээс 2 дахин илүү зай барьж явна.

3.4.4.11 Зам дээр ажиллаж байгаа болон зорчиж байгаа зам усалгааны автосамосвал, автогрейдер, гинжит механизм, эвдэрсэн техникийн дэргэдүүр өнгөрөх, гүйцэж түрүүлэхдээ операторт радио холбоогоороо мэдэгдэж зөрөг хариу авсны дараа замын бартаа саадгүй, үзэгдэх орчин сайн багаа нөхцөлд гүйцэж түрүүлнэ.

3.4.4.12 Замын тэмдэг тэмдэглэгээг дагаж мөрдөнө. Тэмдэг тэмдэглэгээгүй уулзварт уурхайн замын хөдөлгөөний журмын дагуу уулзварт нэвтрэх дарааллыг баримтлан бусад хөдөлгөөнд оролцогчдодоо хүндэтгэн ажиллана.

3.4.4.13 Уурхайн бүсэд замын хөдөлгөөнд оролцох үеийн хурдны дээд хязгаарыг мөрдөнө. Онцгой тохиолдлуудад доорх хязгааруудыг багасгасан байж болохыг анхаарах.

3.4.4.13.1 Зогсоолын талбай, засварын талбай -10км\ц

3.4.4.13.2 Налуу замд -20км\ц

3.4.4.13.3 Технологийн тээврийн тэгш зам -40км\ц

3.4.4.13.4 **Ачилт, буулгалтын хэсэгт -20км\ц**

3.4.5 **Халтиргаатай замд жолоодох.**

3.4.5.1 Сонор сэрэмжтэй жолоодлого гэдгийг шууд утгаар нь ойлгож болно.

3.4.5.2 Халтиргаа гулгаатай үед хэвгий, налуу газар зорчихгүй байх.

3.4.5.3 Халтиргаа гулгаа ихтэй зам талбайгаар зорчиход эрсдэл өндөр тохиолдолд мастерт мэдээлэлж эрсдэлийг арилгасны дараа зорчих.

3.4.5.4 Автосамосвалыг халтиргаатай нойтон зам дээр жолоодохдоо:

3.4.5.4.1 Автомат удаашруулагч ажиллаж байгаа эсэхийг шалга.

3.4.5.4.2 Урд дугуйн тоормосыг идэвхтэй байгааг шалга.

3.4.5.4.3 Техник хоорондын зай хангалттай эсэхийг шалга.

3.4.5.4.4 Халтиргаатай нөхцөлд автосамосвалын тоормосны зам ихсэх тул эдгээр нөхцөлд хурдаа тохируулж жолоодох.

3.4.6 **Ачаа буулгах.**

3.4.6.1 Ачааг буулгах хэсэгт анхаарал болгоомжтой байж буулгах цэгийг сайтар ажигла. Зөөлөн хөрстэй газраар ухарч ачааг буулгахдаа хамгаалах далангийн наана буулга.

3.4.6.2 Ачааг буулгах үед машиныг тэгш гадаргуу дээр байрлуул

3.4.6.3 Буруу талдаа ("сохор талдаа") өөр техник байгаа тохиолдолд хэзээд бүү ухар

3.4.6.4 Овоолго дээр буулгалт хийхдээ овоолгын ирмэгээс 2 автосамосвалын зайд эргэн овоолгын хагарал цууралт ба хөмсгийг ажиглаж аюулгүй гэж үзвэл тэмдэглэсэн газар бульдозерын операторын зүүн гар талд тэгш талбайг сонгон буулгана.

3.4.6.5 Хэрэв хамгаалалтын далангийн өндөр хангалтгүй хагарал цууралт байвал мастерт мэдэгдэнэ.

3.4.6.6 Маш сайн бэхжилттэй, тэгш гадаргуу дээр автосамосвалыг зүүн гар талаараа овоолгын ирмэг рүү харж тойрсон эргэлт хийж ирмэг рүү 45 градус өнцөг барьж зогсооно. Энэ нь жолоочид ухрах үедээ өөрийн талын дугуй болон өнцгийг байнга сайн харж байх боломжоо олгоно.

Шаардлагатай үед энэхүү аюулгүй ажиллагааны заавар нь хүчинтэй хувилбар мөн эсэхийг баримт бичиг

*Зураг 3. Хурд хэтрэлтийн тайлан*

**DT631 42-74 ДАУ** 2024 оны 10-р сарын 29 19:45 - 2024 оны 10-р сарын 30 06:45

**Хурд**




**Хурд хэтрүүлэлт (их 40 км/ц дээш хугацаанд 0 мин.)**

| Эхлэх хугацаа | Үргэлжлэх хугацаа | Дундаж хурд, км/ц | Дээд хурд, км/ц | Хаяг |
|---|---|---|---|---|
| **2024 оны 10-р сарын 29 (Мя) : 11** | | | | |
| 20:46:19 | 00:00:09 | 44 | 44 | Хүдэр |
| 21:32:21 | 00:00:15 | 42 | 42 | Хүдэр |
| 21:34:21 | 00:00:17 | 44 | 44 | Хүдэр |
| 21:42:47 | 00:00:19 | 42 | 43 | [ОВТАЛ Зүүн/төмөртэй,Хөрс зүүн 03/10 Төмөртэй] Хүдэр |
| 22:02:08 | 00:00:14 | 43 | 44 | Хүдэр |
| 22:30:24 | 00:00:17 | 47 | 48 | Хүдэр |
| 22:38:28 | 00:00:10 | 41 | 41 | [ОВТАЛ Зүүн/төмөртэй] Хүдэр |
| 22:56:17 | 00:00:14 | 45 | 45 | Хүдэр |
| 23:22:09 | 00:00:09 | 41 | 41 | Хүдэр |
| 23:22:27 | 00:00:09 | 41 | 41 | Хүдэр |
| 23:31:05 | 00:00:18 | 43 | 44 | [ОВТАЛ Зүүн/төмөртэй,Хөрс зүүн 03/10 Төмөртэй] Хүдэр |
| **2024 оны 10-р сарын 30 (Лх) : 17** | | | | |
| 00:29:12 | 00:00:07 | 43 | 43 | Хүдэр |
| 01:33:57 | 00:00:10 | 43 | 43 | Хүдэр |
| 01:35:01 | 00:00:36 | 43 | 46 | Хүдэр |
| 01:36:06 | 00:00:27 | 42 | 43 | Хүдэр |
| 02:00:59 | 00:00:14 | 44 | 44 | Хүдэр |
| 02:08:35 | 00:00:10 | 43 | 43 | Хүдэр |
| 02:10:00 | 00:00:28 | 42 | 42 | Хүдэр |
| 02:10:57 | 00:00:09 | 42 | 42 | Хүдэр |
| 02:32:01 | 00:00:09 | 44 | 44 | Хүдэр |

Хурд хэтрүүлэлтийн тайлан: DT631 42-74 ДАУ. Хуудас 3

*Зураг 4. Техникүүдийн цахим  хяналтын систет*




*Зураг 5. Тоос хэмжих багаж*



## 2.2 Гадаргын ба газрын доорхи усны нөөцөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

| Д/д | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн ажил | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн ажлын биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Харьяалагдах сав газрын захиргаанаас ус ашиглах дүгнэлт гаргуулах, ус ашиглах гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр төлөх | “Ус ашиглуулах дүгнэлт”-ийг Усны газраар 2024 оны 5-р сарын 21-ний өдөр гаргуулж авсан ба уг дүгнэлтийг үндэслэн Хараа-Ерөө голын сав газрын захиргаатай 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдөр “Ус ашиглах” гэрээг байгуулж, ус ашиглах зөвшөөрөл авч усны төлбөрийг бүрэн төлж хамтран ажиллав. | **35,009,901** | Ус ашиглуулах дүгнэлт, гэрээг хавсаргав /зураг 6/ |
| 2 | Усыг зүй зохистой хэрэглэх дадлыг хэвшүүлэх | Усыг зүй зохистой ашиглах дадлыг хэвшүүлэх зорилгоор мэдээллийн хуудсыг засварын төв болон кемпийн угаалтуурууудын орчимд байршуулсан. Дэлхийн усны өдрөөр ажилчдын дунд сургалт явуулж АХА тэмцээн зохион байгуулав. | Дотоод зардал | Тайланд холбогдох мэдээллийг хавсаргав /зураг 7/ |
| 3 | Гидрогеологийн судалгаа хийлгэх | Уурхайн бүсэд “Уран дриллинг” ХХК-р гидрогеологийн өрөмдлөг, судалгааны ажил гүйцэтгүүлсэн | Дотоод зардал | Тайланд холбогдох мэдээллийг хавсаргав /зураг 8/ |
| 4 | Уурхайн шүүрлийн усыг шинжилгээнд хамруулж стандартын шаардлага хангасан усыг зам талбайн тоосжилтыг дарах, ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар дахин ашиглах замаар усны нөөцийн хомсдолоос сэргийлэх | Уурхайн шүүрлийн усыг 3 шатны тунгаагуурын нуураар дамжуулан хуримтлуулан шинжилгээг улирал тутам хийлгэж стандартын шаардлага хангасан усыг зам талбайн тоосжилтыг дарах, ногоон байгууламжийн усалгаанд ашиглаж байна. | Дотоод зардал | Тайланд холбогдох мэдээллийг хавсаргав /зураг 9/ |
| 5 | Цас борооны усыг цуглуулж ногоон байгууламж, мод үржүүлгийн талбайн усалгааны тодорхой хувийг шийдвэрлэх | Засварын гадна талбайд цас борооны усыг хуримтлуулах зумф хийж хуримтлагдсан усаар мод үржүүлгийн газрын усалгаанд болон машин угаахад ашиглаж туршсан сайжруулалт хийнэ. | Дотоод зардал | Тайланд холбогдох мэдээллийг хавсаргав хавсралт хэсгээс |
| 6 | Усны шинжилгээг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заасан хугацаанд хийлгэх | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан хуваарийн дагуу Сэлэнгэ аймгийн УЦУОШТөвөөр усны шинжилгээг хийлгэж ажилласан. /унд ахуйн хэрэглээний ус-4, шүүрлийн ус-2, орчны голуудаас 2 , хаягдал ус-4 удаа/ | Гэрээний зардал | Мэдээллийг хавсралт хэсгээс |
| | | **НИЙТ** | **35,009,901** | |

*Зураг 7. Худаг хашаажуулсан байдал, усны өдрийг тохиолдуулан “АХА” тэмцээн зохион байгуулсан байдал*





*Зураг 8. Хараа-Ерөө голын сав газраас гаргасан хаягдал усны дүгнэлт*



ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТИЙН






ХАЯГДАЛ УС ХАЯХ, ЗАЙЛУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ

Уурхайн кемп болон засварын төвийн ус нь хатуулаг, магнийн агууламж өндөртэй ялангуяа засварын төвийн усны хатуулаг 7мг-экв/л ээс их буюу MNS 9001:2018 “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан үзүүлэлттэй байсан тул ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулснаар ажилчид шууд ундан хэрэглэх боломжтой болсон . Ус цэвэршүүлэх төхөөрөмжөөс авсан усны шинжилгээний дүнг “Хавсралт” хэсгээс харна уу.

*Зураг 9. Гидрогеологийн судалгаа өрөмдлөгийн ажил хийж буй байдал*





*Зураг 10. Өрөмдсөн цооногийн байршилын зураг*



## Хүснэгт 4. Усны төлбөр төлсөн байдал

| Дансны хуулга | | Тайлант үе: 2024/01/01 - 2024/10/31 | | |
|---|---|---|---|---|
| **Д/д** | **Огноо** | **Гүйлгээний утга** | **Дебет** | **Үлдэгдэл** |
| Данс: | | Усны татварын өглөг /уурхай/ | | |
| | | | Эхний үлдэгдэл: | |
| 1 | 2024/08/08 | Усны төлбөр 2024-1 | 17,504,950.98 | 17504950.98 |
| 2 | 2024/10/22 | Усны төлбөр 2024-1 | 17,504,950.98 | 0 |
| Дт - | 2 | Нийт - 2 ДҮН: | **35,009,901.96** | |
| | | | Эцсийн үлдэгдэл: | 0.00 |

*Зураг 9. 3 шатлалтай ус тунгаагуурын далан*












## 2.3. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

| Д/д | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн ажил | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн ажлын биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | ШТС-ын ачаа буулгах түгээх хэсгийн талбайг бетонжуулах | ШТС-г шинэчлэх стандартын шаардлага хангах ажлын хүрээнд худалдан авалтын тендер зарлагдаад байна. | Гэрээний зардал | Тендерийн хугацаа болоогүй байна. Хавсралт хэсгээс |
| 2 | Шатах тослох материал алдагдах үед яаралтай арга хэмжээ авах асгаралтын иж бүрдэл байршуулах | Асгаралтын иж бүрдэл худалдан авч засварын хэсэгт байршуулсан. Бохирдсон хөрсийг саармагжуулах далан байгуулж ажиллаж байна. | 9,000,000 | Зураг 10 |
| 3 | Хог хаягдлыг төрөлжүүлэн савлаж ангилан ялгах, түр хадгалах цэгт хуримтлуулан зөвшөөрөгдсөн цэгт нийлүүлэх | Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын тохижилт үйлчилгээний газартай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулж, ахуйн хатуу хог хаягдлыг сард 2-3 удаа тээвэрлүүлдэг. | Дотоод зардал | Зураг 11,12 |
| 4 | Ажилчдын ажлын байрны орчимд эко-жорлон суурьлуулах | 2024 онд Тээвэр ложистикийн хэсэгт био жорлон нэмж суурилуулснаар хэсэг бүр эко-жорлонгоор хангагдсан | 10,000,000 | Зураг 13 |
| 5 | Хөрсөн бүрхэвчийг талхлагдахаас сэргийлж олон салаа зам үүсгэхгүй байх, нэгдсэн замын хөдөлгөөний сүлжээ зураг самбар тавих | Уурхайн доторх технологийн замыг нэгдсэн байдлаар төлөвлөж хөмсөг, далан хийж тэмдэгжүүлэлт, камержуулалт хийгдсэн. Шинээр зам үүсгээгүй | Дотоод зардал | Зураг 14 |
| 6 | Хөрс шороонı овоолгыг төлөвлөсөн талбайд эмх цэгцтэй хийх, тэмдэгжүүлэх | Хаягдлын 4 овоолго, шимт хөрсний 1 овоолго, баяжмалын овоолго 12, завсрын бүтээгдэхүүний 20 овоолгыг тус бүр тэмдэгжүүлэн тусгайлан бэлтгэсэн талбайд байрлуулж байна. | Дотоод зардал | Зураг 15 |
| 7 | Шимт хөрсний шимт чанараа алдсан эсэхэд хяналт тавих | Шимт хөрсний овоолгын дээд, дунд, доод давхаргаас хөрсний дээж авч шимт чанарыг Дархан-Уул аймгийн УЦУОШТөвөөр тодорхойлуулсан. Ялзмагийн агууламж 2.10-2.45 мг/л байна. | Дотоод зардал | Хавсаралт хэсгээс |
| **НИЙТ** | | | **19,000,000** | |

*Зураг 10 Асгаралын иж бүрдэл, бохирдсон хөрс саармагжуулах талбай*












*Зураг 11. Хог хаягдлыг тээвэрлэх гэрээ*



БАТЛАВ

"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Т.ДУГАРЖАВ

БАТЛАВ

ХҮДЭР СУМЫН ХҮДЭР ТОХИЖИЛТ ОНӨААТҮГ-ЫН ДАРГА

Ж.ОДЖАРГАЛ

**ТӨМӨРТЭЙН ХҮДРИЙН УУРХАЙН**
**АХУЙН ХОГ ХАЯГДЛЫГ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ**

2023 оны 02-р сарын 06-ны өдөр №ХТҮ-АГГ-2023-04 Дархан-Уул аймаг

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Нэг талаас "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК РД:2051303, түүнийг төлөөлж Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга М.Анхбаатар /цаашид "Захиалагч" гэх/, нөгөө талаас Хүдэр сумын Хүдэр тохижилт, түүнийг төлөөлж дарга Ж.Оджаргал..../цаашид "Гүйцэтгэгч"гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Монгол Улсын ариун цэврийн тухай, Хог хаягдлын тухай хуулиудыг хэрэгжүүлэх иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлыг тээвэрлэх, энэ гэрээгээр төлбөр төлөхтэй үүссэн харилцааг зохицуулахад оршино.

**ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА**

2.1 Ажил эхлэх ба дуусах хугацаа: 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд ажлыг хийж гүйцэтгэнэ.
2.2 Захиалагч 12-24 цагийн өмнө ажлын захиалгыг өгнө.
2.3 Гүйцэтгэгч тал Захиалагч талын өгсөн дуудлагын дагуу 1-2 хоногийн дотор ажлыг гүйцэтгэнэ.

**ГУРАВ. АЖЛЫН ХӨЛС, БУСАД ТӨЛБӨР**

3.1. Хүдэр сумын ИТХ-ын 2018 оны 06-р сарын 06-ны өдрийн 82 тоот тогтоолыг үндэслэн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа чиглэлийн дагуу сарын төлбөрийг төгрөгөөр тооцож 1 сард 550,000.0 /таван зуун тавин мянга/ төгрөг, жилд 6,600,000.0 /Зургаан сая зургаан зуун мянга/ төгрөгийг "Хүдэр тохижилт" ОНӨААТҮГ-ын **151400135150** тоот дансанд шилжүүлнэ.

| д/д | Хог хаягдлыг үүсгэгч | Үнэлгээ | Сард явах | жилээр төлөх хэмжээ /төгрөг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Ажилчид | 1000 | | |
| 2 | Цайны газар | 5000 | | |
| 3 | Хог үүсгэсний төлбөр /сар/ | 150000 | | 1800,000 |
| 4 | Тээврийн зардал | 200000 | 2 удаа | 4,800,000 |
| | **Нийт** | | | **6,600,000** |

3.1 Дээрх үнэнд НӨАТ орсон ба холбогдох бусад бүх зардал багтсан болно.
3.2 Өмнө нь төлөвлөгдөөгүй, гэрээнд тусгагдаагүй, зайлшгүй нэмж хийх шаардлагатай ажил гүйцэтгэвэл ажлын хөлс, түүнийг төлөх хэлбэр, хугацааг талууд тухайн үед нь харилцан тохиролцоно.

*Зураг 12 Хог ачиж байгаа байдал*





*Зураг 13. Эко жорлон суурьлуулсан  байдал*





*Зураг 14. Замын байдал*





*Зураг 15 Хөрсний овоолго хаягжуулсан байдал*









## 2.4. Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

| Д/д | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн ажил | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн ажлын биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Газрын хэвлийг ашигласан төлбөрийг хугацаанд нь төлөх | Газрын хэвлийг ашигласан төлбөрийн 1,2,3,4 -р улирлын төлбөр нийт **259,393,763** төгрөг төлсөн | Дотоод зардал | Газрын төлбөр төлсөн баримтуудыг Хүснэгт3 хавсаргав |
| **НИЙТ** | | | Дотоод зардал | |

### Хүснэгт 5. Газрын төлбөр

| Дансны хуулга | | | | | | Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Дансны хуулга** | | | | | | | |
| Д/д | Огноо | Гүйлгээний утга | | | | Дебет | Үлдэгдэл |
| Данс : | 3406-4-1-00-000-000-0-0-00-000-00-001 | Газрын төлбөрийн өглөг /Сэлэнгэ/ | | | | | |
| 1 | 2024/02/28 | Газрын татварт Сэлэнгэ 2024.1 | | | | 31,797,849.00 | 34689630 |
| 2 | 2024/04/26 | Газрын төлбөр /Сэлэнгэ 2024-01/ 1240200827773 | | | | 33,050,592.00 | 1639038 |
| 3 | 2024/04/26 | Газрын төлбөр /Сэлэнгэ 2024-01/ | | | | 468,297.00 | 1170741 |
| 4 | 2024/06/19 | Газрын татвар Сэлэнгэ 2024.02 улирал | | | | 468,297.00 | 64848441 |
| 5 | 2024/06/19 | Газрын татвар Сэлэнгэ 2024.02 улирал | | | | 31,797,849.00 | 33050592 |
| 6 | 2024/06/19 | Газрын татвар Сэлэнгэ 2024.02 улирал | | | | 33,050,592.00 | 0 |
| 7 | 2024/08/16 | Газрын татвар Сэлэнгэ 2024-03 | | | | 468,297.00 | 64848441 |
| 8 | 2024/08/16 | Газрын татвар Сэлэнгэ 2024-03 | | | | 31,797,849.00 | 33050592 |
| 9 | 2024/08/16 | Газрын татвар Сэлэнгэ 2024-03 | | | | 33,050,592.00 | 0 |
| 10 | 2024/09/30 | Газрын төлбөр 2024-4 | | | | 31,797,848.00 | 33050592 |
| 11 | 2024/11/05 | Газрын төлбөр 2024-4 | | | | 33,050,592.00 | |
| Дт - | 11 | Нийт - | 22 | | ДҮН: | **259,393,763.00** | |
| | | | | | | Эцсийн үлдэгдэл: | 0 |

## 2.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

| Д/д | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн ажил | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн ажлын биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Батлагдсан технологийн замаас гадна зам гаргахгүй байх | Батлагдсан технологийн замаас гадна зам гаргаагүй | Дотоод зардал | Сүүлийн жилүүдэд зам гаргааүй |
| 2 | Хуурайшилттай үед зам дагуу тоосжилт дарах усалгаа хийх | Зам дагуу тоосжилт дарах усалгааг тогтмол / хийж ажилласан | Дотоод зардал | |
| **НИЙТ** | | | **Дотоод зардал** | |

## 2.6. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

| Д/д | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн ажил | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн ажлын биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Ажилчдын кемпэд галт зэвсэг болон бусад зэвсэг хэрэгсэл байлгахыг хориглоно | Ажилчдын байранд болон уурхайд галт зэвсэг байрлуулах, хэрэглэхийг хориглодог | Дотоод зардал | Компанийн дотоод журамд хориглодог. |
| 2 | Ажилчдад амьтны тухай хууль, байгаль хамгаалах талаар сургалт хийх | Ажилчдад амьтны тухай хууль болон байгаль орчны тухай хуулиар 14 хоног тутам сургалт зохион байгуулж гарын авлага, тараах материал өгч ажилласан | Дотоод зардал | Зураг 16 |
| 3 | Шувууны нислэгийн чиглэл өөрчлөгч /үргээгч/ болон шувууны суулт /үүр/ суурилуулах | Цахилгаан дамжуулах агаарын шугамд шувуу үргээгч байрлуулах ажлын худалдан авалт хийгдэхээр гэрээ байгуулагдсан | Дотоод зардал | |
| **НИЙТ** | | | Дотоод зардал | |

*Зураг 16. Сургалтын зураг*





## 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

| Д/д | Нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн ажил | Нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн ажлын биелэлт | Зардал | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ аймагт 3000 мод тарих | Хүдэр суманд Уурхайн захиргааны орчимд 6500ш нарс мод суулгасан | 9,750,000 | Тендер шалгаруулалтаар “Алд дэлгэм” ХХК шалгаран тус компаниас 6500 нарсны суулгац аван уурхайн ажилчид мод суулгах ажлыг гүйцэтгэсэн |
| 2 | | Төмөртэй уурхайд мод үржүүлгийн газар байгуулж 30,000 ш орчим нарсны үрсэлгээ хийж ажиллаа. | дотоод зардал | Зураг 17,18 |
| **НИЙТ** | | | **9,750,000** | |

*Зураг 17 Мод тарьсан байдал*





*Зураг 18 Мод үржүүлгийн газар*





## 4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:

| Д/д | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Дүйцүүлэн хамгаалалтын арга хэмжээг сонгон авсан 10 га талбайд хийх | Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Баянцагаан 2-р багийн нутаг дэвсгэрт орших Цагаан шилүүстэй нэртэй газарт 10 га талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгүүлэхээр “Эв энержи” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна._ | 151,000,000 | Гэрээг хавсаргав Зураг 19 |
| **НИЙТ** | | | **151,000,000** | |

*Зураг 19. Гэрээ, нөхөн сэргээлт хийсэн байдал*


ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ЧАГНААДОРЖ

Б.БАТМӨНХ

**ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Дугаар № ***ДААТҮТӨХК/20240102164***

2024 оны 10-р сарын 28-ны өдөр Дархан-Уул айма

Нэг талаас **“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК** РД: 2051303 (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас “Эв-Энержи” ХХК РД: 5921791 (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөө байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалда бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Ажил” гэх) болон үнэ төлөхтэ холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу “Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажил” гүйцэтгэ ажлын үнэ нь **151,540,000** *(Нэг зуун тавин нэгэн сая таван зуун дөчөн мянган* төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээ хэмжээ байна.

   1.1 Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх ажил үйлчилгээни үнэ. (НӨАТ-орсон дүн)

2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч “Эв-Энержи” ХХК-ийн харилцах ***Хаан банк***-ны ***5024916735*** дугаар дансанд шилжүүлнэ.

3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

   3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл; **2024.10.10 /№01/1905/**
   3.2 Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт; **2024.09.29**
   3.3. Гэрээний тусгай нөхцөл;
   3.4 Гэрээний ерөнхий нөхцөл;
   3.5. Техникийн тодорхойлолт;
   3.6. Ажлын даалгавар; /Ажлын даалгаварыг баталгаажуулсан/
   3.7. Ажил гүйцэтгэх хуваарь. /хуанлын **60** хоног/

4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхи этгээдүүд төлөөлнө. Үүнд:





## 5.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээны төлөвлөгөө | Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээны төлөвлөгөөний биелэлт | Зардал, төг | Тайлбар |
|---|---|---|---|
| Байхгүй | - | - | Уурхайн үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрт суурьшиж буй иргэд байхгүй учир нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ явагдаагүй |
| **НИЙТ** | | - | - |

## 6.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | Зардал, төг | Тайлбар |
|---|---|---|---|
| Байхгүй | - | | -Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд ШУАкадемийн археологийн хүрээлэнгийн судалгааны багийн хийсэн археологийн тандалт судалгаа, ШУТИС-ийн палеонтологийн төв лабораторийн хээрийн судалгааны явцад нийт төслийн талбайн хэмжээнд археологи, палеонтологийн олдвор, ямар нэгэн түүхийн дурсгал илрээгүй байна.<br>Уурхайн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвд хамаарах олдвор олдсон тохиолдолд уурхайн үйл ажиллагааг зогсоож, мэргэжлийн байгууллагуудад мэдэгдэж хамтран ажиллана. |
| **НИЙТ** | | - | - |

## 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

| Д/д | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээний биелэлт | Зардал, төг | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| **1** | Болзошгүй осол, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх | Ажилчдад ХАБЭА-н ажлын хувцас, малгай хошуувч , гутал | Нийт уурхайн ажилчдад өвөл зуны ажлын хувцас, малгай, гутлыг 1-2 жилд нормоор олгодог бөгөөд 2024 оны төлөвлөгөөний дагуу ХАБЭА норм бүрэн олгогдсон | Дотоод зардал | |
| 2 | | Гал унтраах багаж, хэрэгсэл байрлуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, гал унтраах урьдчилан сэргийлэх тоноглолуудыг бэлдэх зохион байгуулах | -Ажлын байр болон амрах байр, цайны газарт галын нэгдсэн дохиоллын систем суурилуулсан. -Бүх техник, ажлын болон амрах өрөөнүүдэд галын хор байршуулсан -Нийт ажилчдад ХАБЭА-н зааварчилгааны сургалтайнд гал түймэртэй тэмцэх талаар сургалт зааварчилгааг тогтмол өгдөг бөгөөд 1 удаа дадлага сургуулийг зохион байгуулсан | 2,000,000 | Зураг 20.21 |
| 3 | | Химийн бодис, эмнэлгийн хог хаягдал, бензин ШТМ алдагдах үед асгаралтын иж бүрдэл байршуулах | Уурхайн засварын газарт асгаралтын иж бүрдэл байршуулсан | 1,500,000 | Зураг 17 |
| **НИЙТ** | | | | **3,500,000.00** | |

*Зураг 20. Гал унтраах багаж хэрэгсэл*














*Зураг 21.Галын аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар дадлага сургуулилт хийж буй байдал*

1 Ажилтнуудын дунд хийгдсэн Эрүүл мэндийн чиглэлийн ажлууд

- ✓ Анхан шатны үзлэг :Өглөө бүр бүх ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж ажилд гаргадаг.
- ✓ Өдөр бүр нэгдсэн дасгал хөдөлгөөн хийж хэвшсэн.
- ✓ 7 хоног бүр хэсэг тус бүрт эрүүл мэндийн сургалт явуулдаг
- ✓ Дархалаа дэмжих үйлчилгээ: 338 ажилтанд 5 нэр төрлийн витамин, ундаа, цай, өвөл хаврын улиралд халуун аарцаар үйлчилж ажилласан байна.

✓ Урьдчилан сэргийлэх арга хэмжээ: Хачигт энцефалит өвчнөөс сэргийлэх вакцин, томуугийн вакцин зэрэг дархалаа тотоох вакцинжуулалт хийсэн .




Хүснэгт 6. Витамин олголтын мэдээ

| Д/Д | Нэр төрөл | 2024 оны 01 сард | Хавар | Намар | Нийт тоо | Нэг бүрийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Хүний тоо** | **Хүний тоо** | **Хүний тоо** | | | |
| 1 | Витамин Д | 140 | | 338 | 478 | 10513 | 5025214 |
| 2 | Витамин С | 140 | | 338 | 478 | 3631 | 1735618 |
| 3 | Витамикс | | 332 | | 332 | 14200 | 4714400 |
| 4 | Омега | | 332 | | 332 | 9987 | 3315684 |
| 5 | Цайр | | 332 | | 332 | 6410 | 2128120 |
| **Бүгд** | | | **332** | **338** | | | **16.919.036** |

Хүснэгт 7. Артишок олголтын мэдээ

| Д/Д | Бэлдмэлийн нэр | Олгосон хугацаа | | Нийт тоо | Нэг бүрийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2024.02 -04 сар | 2024.05 -08 сар | | | |
| 1 | Артишок цай | 672 | 0 | 672 | 7980 | 5362560 |
| 2 | Артишок ундаа | 1598 | 7546 | 9144 | 2800 | 25603200 |
| Дүн | | | | | | **30.965.760** |

Хүснэгт 8. Вакцинжуулалтын  мэдээ

| **Д/Д** | **Цех хэлтэсүүд** | **Хавар** | **Намар** | **Нэг бүрийн үнэ** | **Бүгд үнэ** |
|---|---|---|---|---|---|
| | | **Хүний тоо** | **Хүний тоо** | | |
| 1 | Хачигны вакцин 1.2-р тун | 27 | | | 0 |
| 2 | Хачигны вакцин 3-р тун | 51 | | | 0 |
| 3 | Томуугийн вакцин | | 277 | 42500 | 11772500 |
| | **Бүгд** | **78** | **338** | | **11772500** |

*Зураг 22. Ажилтнуудын дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийн үйлчилгээ авч буй байдал*













## 8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

| Д/д | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх ажлууд | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт | Зардал, төг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Ахуйн хог хаягдлыг ангилах, хогийн савны хүртээмжийг нэмэгдүүлэх /шинээр хийх байрлуулах/ | Ангилдаг хогийн савыг хаягдал тэвш ашиглан цаас, хуванцар, ахуйн хог хаягдал гэсэн 3 ангиллаар түр хадгалах сав хийж байршуулав | Дотоод зардал | Мэдээлэл хавсргав /зураг 23/ |
| 2 | Ахуйн хог хаягдлыг орон нутгийн нийтийн аж ахуйн газартай гэрээ байгуулан, нийлүүлэх | - Хүдэр сумын тохижилт ОНӨААТҮГазартай "Хог хаягдлын" гэрээ байгуулж, нийт 21 удаа 95,3 тн хог хаягдал ачуулсан. | 6,600,000 | Мэдээлэл хавсаргав /зураг 11,12/ |
| 3 | Хог хаягдлын цэг, бохирын цоонogт ариутгал хийх | Уурхайн дотоод нөөц бололцоог ашиглан хогийн цэгүүдэд жавелионы уусмал ашиглан хог ачилт бүрийн дараа ариутгал хийдэг | Дотоод зардал | Зураг 24 |
| 4 | Байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулах, ангилах ялгах, хог хаягдлыг буруулах, дадал зуршлыг хэвшүүлэх | Уурхайн ажилчдад хог хаягдлын талаарх компанийн дүрэм, зааврыг танилцуулж сургалт явуулдаг | Дотоод зардал | Зураг 25 |
| 5 | Уурхайн орчмын хог хаягдлыг цэвэрлэх нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах | Долоо хоног бүрийн пүрэв гарагт уурхайн орчмын газруудад нийтийн цэвэрлэгээ хийж хэвшүүлсэн | Дотоод зардал | Зураг 26 |
| 6 | Технологийн хог хаягдлыг боловсруулан өөрийн дотоод хэрэгцээнд эргүүлэн ашиглах | Технологийн хог хаягдлыг уурхайн дотоод зам талбайг засахад тогтмол ашигладаг | Дотоод зардал | Мэдээлэл хавсаргав |
| 7 | Аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагаар зайлуулах, устгуулах | 17 тн ашигласан тос маслыг "ЮТО" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 2024 оны 6-р сард өгч устгуулсан. Лабораториос гардаг химийн бодисын хаягдал болон эмнэлгийн хог хаягдлыг үйлдвэр дээр хуримтлуулж гэрээлсэн ААН-р устгуулдаг | 2,500,000 | Зураг 27 |
| 8 | Аюултай хог хаягдлыг ангилан, түр хадгалах цэгт хуулийн хүчинтэй хугацаанд зориулалтын саванд хадгалах | - Хаягдал тосыг гидрийн шингэн, хропын тос, хөдөлгүүрийн тос гэж ангилан шаардлага хангасан саванд түр хадгалж байна.<br>- Уурхайн Лабораториос гардаг химийн бодисын хаягдал болон эмнэлгийн хог хаягдлыг зориулалтын шар саванд түр хадгалдаг | 90,000 | Хог хаягдлын мэдээг хавсралтаас |
| **НИЙТ** | | | **9,000,000** | |

*Зураг 23. Ангилдаг хогийн савыг хаягдал тэвш ашиглаж хийсэн байдал*



*Зураг 24. Ариутгал хийж байгаа байдал*



*Зураг 25 Сургал хийж байгаа байдал*



*Зураг 26. Бүх нийтээрээ цэвлэгээ хийж байгаа байдал*







*Зураг 27. Аюултай хог хаягдал түр хадаглах цэг, устгуулахаар ачил хийж буй байдал*







АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ҮҮСГЭГЧИЙН ТАЙЛАНГИЙН МАЯГТ



АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

## Хүснэгт 9 . Хог хаягдлын мэдээ. 2024.01.01-2024.11.01

“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр”ХХК-ны Төмөртэй уурхайн 2024 оны хог хаягдлын тайлан мэдээлэл

<table>
<tr><th colspan="2">Ангилал</th><th>Хог хаягдлын төрөл</th><th>Нийт хэмжээ</th><th>Тайлбар</th></tr>
<tr><td rowspan="19">Аюултай хог хаягдал</td><td rowspan="4">Энгийн хог хаягдал</td><td>Ахуйн хатуу хог хаягдал /кг</td><td>95300</td><td>“Хүдэр Тохижилт” ОНӨААТҮГ-т нийлүүлдэг</td></tr>
<tr><td>Хаягдал бохир ус /$м^3$</td><td>4938</td><td>250 хүний хүчин чадалтай Цэвэрлэх байгууламжтай</td></tr>
<tr><td>Хуванцар /кг</td><td>52</td><td>Гэрээт “SESL” ХХК-д нийлүүлдэг</td></tr>
<tr><td>Шингэн хаягдал /хоол хүнсний/ кг</td><td>5421</td><td>Гахайн фермд нийлүүлдэг</td></tr>
<tr><td rowspan="9">Ашигласан тос масло, бусад</td><td>Гидрийн шингэн /л</td><td>3481</td><td rowspan="9">Хадгалагдаж буй үлдэгдэл: 8946 л байна. Гэрээт байгууллагад шилжүүлсэн: 17000л /Гэрээт “ЮТО” ХХК-д нийлүүлдэг/</td></tr>
<tr><td>Хөдөлгүүрийн тос /л</td><td>7310</td></tr>
<tr><td>Хроп /л</td><td>2074</td></tr>
<tr><td>Редукторын тос</td><td>3614</td></tr>
<tr><td>Тосол /л</td><td>525</td></tr>
<tr><td>Нийт</td><td>17004</td></tr>
<tr><td>Тос агуулсан хаягдал (шингэн хадгалах танк) (борлуулсан/үлдэгдэл) / ш</td><td>82</td></tr>
<tr><td>Хуванцар сав</td><td>27</td></tr>
<tr><td>Арчдас материал /кг</td><td>432</td></tr>
<tr><td>Түлш, масло, гидрийн шүүр/кг</td><td>757</td></tr>
<tr><td rowspan="2">Эмнэлгийн хог хаягдал</td><td>Хурц иртэй, үзүүртэй хог хаягдал /кг</td><td>3.8</td><td rowspan="2">Дархан хотын НААҮГ-т нийлүүлдэг</td></tr>
<tr><td>Халдвартай хог хаягдал /кг</td><td>32,3</td></tr>
<tr><td rowspan="4">Химийн бодисын хог хаягдал</td><td>Химийн хатуу хог хаягдал /кг</td><td>45,9</td><td rowspan="4">Гэрээт ААН-/Элемент ХХК/-д нийлүүлдэг</td></tr>
<tr><td>Химийн хагарсан шил сав /ш</td><td>47</td></tr>
<tr><td>Химийн бодисын хуванцар сав / ш</td><td>74</td></tr>
<tr><td>Химийн бодисын шилэн сав /ш</td><td>38</td></tr>
<tr><td colspan="2" rowspan="2">Бусад</td><td>Бүх төрлийн баттерей, аккумлятор /ш</td><td>22</td><td>Зориулалтын байранд хадгалагдаж байна</td></tr>
<tr><td>Ашиглалтаас гарсан дугуй /ш</td><td>67</td><td>Уурхай дээр хадгалагдаж байна</td></tr>
</table>

Тайлан гаргасан: Байгаль орчны инженер П.Алтангэрэл Хянасан:
Уурхайн дарга А.Ганзориг

## 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

| Д/д | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт | Зардал, төгрөг | Үр дүн |
|---|---|---|---|---|
| **Агаар** | | | | |
| 1 | •Агаарын бохирдлын шинжилгээ (NO2, SO2, CO, Тоос)<br>•Агаарын тоосны шинжилгээ (TSP, PM10, PM2.5)<br>•Дуу шуугиан | -Ил уурхайн дотоод зам<br>-Ил уурхайн карьер<br>-Баяжуулах үйлдвэр<br>-Ажил буулгах терминал<br>-Уулын парк орчмоос<br>2024 оны 5, 8 дугаар сарuудад нийт 2 удаа<br> Нийт тоос, PM10 тоосонцор, PM2.5 тоосонцор<br> Азотын давхар исэл (NO2)<br> Хүхэрлэг хий (SO2)<br>үзүүлэлтүүдээр агаарын шинжилгээг хийлгэсэн. | | Агаарын шинжилгээний дүнгээр нийт тоос болон тоосонцрын агууламж, агаарын бохирдлын хэмжээ MNS 4585:2016 стандартын шаардлага хангаж байна. Тоосжилтыг бууруулах зорилгоор техникүүдэд хурдны хязгаар тогтоох, зам талбайг тогтмол услах ажил хийгдэж байна. |
| **Хөрс** | | | | |
| 2 | •Хөрсний агрохимийн үзүүлэлт (pH, ялзмаг, NO3, K2O, P2O5)<br>•Механик бүрэлдэхүүн<br>•Хүнд металлууд (Cr, Pb, Cd, Ni, Zn, Cu, Co, Mn) | -Машин механизмын зогсоолын орчин<br>-Овоолго хойд, баруун ,зүүн<br>-Баяжуулах үйлдвэрлэлийн орчин<br>-Шоп засварын орчин<br>-Кемпийн орчин<br>-Хогийн цэгийн орчин<br>-ШТС<br>-Дотоод зам<br>-Уурхайн нөлөөлөлд өртөөгүй талбай кемпээс зүүн тийш 300м зайнаас<br>2024 оны 5,8 сард<br> Ялзмаг, %<br> Нитрат, NO3 | | -Хөрсний агрохимийн үзүүлэлтийн шинжилгээний дүнгээс харахад овоолгын баруун хэсгээс бусад цэгт сульфатын хүлцэх хэмжээ 1,3-9,9 дахин хэтэрсэн байгаа нь Уурхайгаас олборлож буй хүдэр нь хүхрийн агууламж өндөртэй байдгаас шалтгаалсан гэж үзэж байна.<br>-Шимт хөрсний овоолгын ялзмагийн агууламж 2.10-2.45% тай байна.<br><br>- Кемпийн авто зогсоолын талбайн хэсэгт хөрсний нефтийн бүтээгдэхүүний агууламж стандартаас 3.9 дахин давсан үзүүлэлттэй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Сульфат, $SO_4$<br>Аммони, $NH_4$<br>pH | | байсан тул хөрсийг хуулж, саармагжуулах талбайд шилжүүлэн шинэ хөрс дэвссэн бөгөөд дахин шинжилгээ хийхэд хүлцэх хэмжээнд байна.<br>-7 хэсэгт Хүнд металлын шинжилгээ хийхэд стандартын шаардлага хангаж байна. |
| **Усан орчин** | | | | |
| **3** | •Усны ерөнхий химийн шинжилгээ<br>•Бактереологийн шинжилгээ<br>•Хүнд металлын шинжилгээ | -Уурхайн худаг<br>-Кемпийн худаг<br>-Ус цэвэршүүлэх төхөөрөмж<br>-Цайны газрын шугам<br>-Цэвэрлэх байгууламж<br>-Шүүрлийн ус<br>-Орчны гадаргын ус /Сөдтэй гол Төмөртэй гол/<br>2024 оны 03, 04, 05, 08,10 саруудад дээж авч шинжилгээ хийлгэсэн | | -Уурхайн кемпийн худгийн усны магнийн агууламж стандартаас 1.7 дахин давсан үзүүлэлттэй байв.<br>-Засварын төвийн худгийн усанд хатуулаг 1.3 дахин их, кальци-1,5 дахин их, харин фтор-1,5 дахин бага үзүүлэлттэй байв.<br><br>Дархан-Уул аймгийн “Ус суваг” ХХК-иар усны нөөцийн савнуудад ариутгал хийлгэж, засварын төв болон кемпэд ус цэвэршүүлэх төхөөрөмжүүдийг суурилуулан, ашиглаж байна.<br>-Шүүрлийн ус нь хаягдал усны MNS 4943:2015техникийн шаардлага хангаж байна.<br>-Цэвэрлэх байгууламжийн саарал ус нь MNS 4943:2015 стандарт дахь хүлцэх хэмжээнээс биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 6,8 дахин их, химийн хэрэгцээт хүчилтөрөгч 5,7 дахин их байна. |
| **дүн** | | | **2,100,000** | |

# 10. Аймаг, сумын  Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ

## 10.1. Хүдэр сумын ногоон байгууламжийг хамгаалах хамгаалалтын хашаа шийдвэрлэх

Гэрээний 4.13-д заасан ажил: Сумын төвийн ногоон байгууламжийг хамгаалах, нэмэгдүүлэх зорилгоор 360 м төмөр хашааг үргэлжлүүлэхээр төлөвлөснөөс 300м-ийг хашаажуулсан. Материалын зардал: 5,600,000 төгрөг, ажил гүйцэтгэсэн зардал: 3850,000 төгрөг.

Нийт 9,450,000 төгрөгөөр гүйцэтгэсэн байна.





## 10.2 Хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн хүрээнд Хүдэр сумын  төвлөрсөн хогийн цэгийн ахуйн хогыг түрж булшлах ажил

Нэг дугуйт авто ачигч 7 хоногт ажиллах хугацаанд 4982 л дизель түлш зарцуулсан байна. /4982л*4300=21,422,600 төгрөг/ Ажилласан авто ачигчийн операторын цалин хоол хүнсний зардал 197,250*2*7=2,761,500 төгрөг. Нийт **24,184,100** төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.












## 10.3 Хүдэр сумын хүсэлтийн дагуу хог хаягдал ялгах ажлыг дэмжиж ажилласан

Хүдэр сумын Засаг даргын хүсэлтээр “ДТҮ” ХХК-ийн гүйцэтгэх захирлын зөвшөөрлөөр 200 литрийн 100 ш хоосон төмөр торхыг 2024 оны 8-р сарын 30-ны өдөр Хүдэр сумын “ХҮДЭР ТОХИЖИЛТ” ОНӨААТУҮГ-т хүлээлгэж өгсөн. /1 бүрийн үнэ 8800 төгрөг нийт 880,000 төгрөг/




## **10.4** Гамшгийн үед хамтран ажиллах

Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн үед Хүдэр сумын аюулгүй нөөцөд зориулж нийт 15.784.000 төгрөгийн өртөг бүхий 10тн хивэг, алслагдсан малчдад тусламж хүргүүлэх техникт шаардлагатай 2500л дизель түлш, шаардлагатай үед ашиглах автогрейдрийн бэлэн байдлыг хангаж ажилласан.





## 10.5 Бусад ажлын хүрээнд

- ✓ 2024.10.17-ны өдрийн “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-ны захиралын тушаалаар “Алтан намар” спортын 4 төрөлт шилжин явах цомын тэмцээний удирдамж батлагдав. /Тэмцээний нийт төсөв 7,020,000 төгрөг/
- ✓ 2024 онд 4 оюутны сургалтын төлбөр 16,993,000 төгрөгийг шийдвэрлэж ажиллаа

## 11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

| Д/д | Төлөвлөсөн арга хэмжээ | Төлөвлөгөөний биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | БОННҮ-ны тайланд нэмэлт тодотгол хийлгэх | БОННҮ-ны тайланд нэмэлт тодотгол хийлгэх ажлын худалдан авалт зарлагдсан | 40.000.000 | Тендерийн үр дүн гараагүй байна. |
| 2 | Байгаль орчныг хамгаалах жилийн тайлан, төлөвлөгөөг БОНХЯ болон орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь гаргаж өгч байх | БОМТ-ний хэрэгжилтийг гарган танилцуулж байна. | Дотоод зардал | Хуулийн хугацаанд тайланг хүргүүлж байна |

## 12.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

| Д/д | БОМТ-ний биелэлтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчидад тайлагнах төлөвлөгөө | БОМТ-ний биелэлтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчидад тайлагнах төлөвлөгөөний биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар | 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайланг Сэлэнгэ аймгийн БОАЖГ-т хянуулж ЗДТГ-т хүргүүлнэ. | | Тайланг хүргүүлсэн |
| 2 | Нөлөөлөлд өртөгч оршин суугчид | Уурхайн БОННҮ тодотгол хийлгэж байгаа тул ИНХ-р хэлэлцүүлсэн | Дотоод зардал | БОННҮ гэрээ, ИНХ-р хэлэлцүүлсэн зураг, албан тоот, протоколыг хавсаргав |
| 3 | БОУАӨЯ-ны ХБОБНУ-ын газарт | 2024 оны БОМТ-ний биелэлтийн тайланг Сэлэнгэ аймгийн БОГ-т танилцуулан дэмжигдсэний дараа БОУАӨЯ-ны ХБОБНУ-д хүргүүлэн, батлуулна | Дотоод зардал | |

## 13. Дүгнэлт

2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 62.339.000 төгрөгийн 47 зорилт арга хэмжээг 525,553,664 төгрөгийн төсвөөр хийж гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 10 Нийт зарцуулсан зардал

| Д/д | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Дүн /сая төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 313,703,664 |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт | 9,750,000 |
| 3 | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 151,000,000 |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | - |
| 5 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | - |
| 6 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт | Үйл ажиллагааны зардал |
| 7 | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт | 9,000,000 |
| 8 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт | 2,100,000 |
| 9 | Аймаг, сумын Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ | Үйл ажиллагааны зардал |
| 10 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт | 40,000,000 |
| **НИЙТ** | | **525,553,664** |

## 14. Хавсралт:

1. Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хуулбар
3. Хайгуулын ажил, ТЭЗҮ-г хүлээн авсан тушаал, тэмдэглэл
4. Химийн бодисын ашиглалтын мэдээ, тайлан
5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийсэн лабораторийн шинжилгээний үр дүнгүүд
6. БОХ-3 маягт. Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн жилийн мэдээ
7. Эрх бүхий байгууллагуудаас гүйцэтгэсэн ажлыг нь хүлээж авсан актын хуулбарууд /"ЮТО" ХХК/
8. Хуваарьт аудитын дүгнэлт, зөвлөмж ба түүний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан
9. Байгууллагын хариуцлагын даатгалын хуулбар
10. Нөөц ашигласны төлбөр тушаасан баримтын хуулбар
11. Нөөцийн хөдөлгөөний тайлангийн хуулбар
12. Хилээр экспортод гаргасан бүтээгдэхүүний талаар гаалийн албанаас гаргасан мэдээ

*Жич: Хавсралтыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар 29-ний өдрийн А/618 тоот тушаалын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 3 дугаар хавсралтыг үндэслэн боловсруулсан. Мөн уг хавсралтаас дээр дурьдагдсан болон уурхайн үйл ажиллагаатай холбоогүй хавсралтуудыг хассан болно.*